



## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын  
2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний  
төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн  
аудитын тайлан

### “СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”



ХАНДИВ ТУСЛАМЖИЙН ОРЛОГЫН 35.6 ХУВИЙГ ТӨРИЙН САНГИЙН  
ДАНСАНД БАЙРШУУЛАЛГҮЙ ЗАРЦУУЛЖЭЭ.

<p>Тайланг бэлтгэсэн:  Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт.....3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-5</p>
<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат</p> <p>Аудитын менежер Ш.Мөнхбаяр</p> <p>Ахлах аудитор С. Батцэцэг</p> <p>Аудитор У. Батсүрэн</p>	<p><b>БҮЛЭГ-1</b></p> <p>1.1. Санхүүжих дундаж хүүхдийн тоо хүчин чадлаасаа харилцан адилгүй батлагдаж байна .....6-7 1.2.Хувьсах зардлыг төсөвлөхдөө санхүүжих дундаж хүүхдийн тоонд тулгуурлан төлөвлөжээ.....7 1.3. Хоолны зардлыг Засгийн газраас баталсан дүнгээр тооцсон байна ..... 7 1.4. Хуульд заасан нэг удаагийн буцалтгүй тусламж, мөнгөн тэтгэмжийг холбогдох баримт бичгийг үндэслэн зөв төлөвлөсөн байна..... 7 1.5. Санхүүжилт батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгогджээ ..... 7 1.6. Хандив, тусламжийн орлогын 35.6 хувийг төрийн сангийн дансанд байршуулалгүй зарцуулжээ.....8-10</p>
<p>Гэрээт аудитор Д.Отгонбаяр</p> <p>2018 оны 11 дүгээр сар</p> <p>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7037-3089, 7037-4605 дугаарын утсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Дархан-Уул аймгийн Дархан сум, 14-р баг, Аймгийн ЗДТГ-ын байр, 306 тоот</p>	<p><b>БҮЛЭГ-2</b></p> <p>2.1 Төрийн өмчит цэцэрлэгүүд мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдсан байна.....11 2.2. 5 ба 24 дүгээр цэцэрлэгээс бусад нь ажиллагсдын цалинг Засгийн газрын тогтоолд заасны дагуу тогтоож, олгосон байна.....11-12 2.3.Удирдах ажилтнуудад тушаал шийдвэргүйгээр нэмэгдэл хөлс олгох зөрчил нийтлэг гарч байна.....12-14 2.4. Зарим цэцэрлэгүүдийн удирдах болон санхүүгийн ажилтнуудын цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулан олгосон байна .....14-15 2.5. Шүүхийн шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны цалинд 5,204.0 мянган төгрөгийг нөхөн олгожээ.....15 2.6. Зарим цэцэрлэгийн бэлтгэсэн хүнсний материалын үнэ зах зээлийн үнээс өндөр байна.....15-16 2.7. Хоолны зардлыг 4, 7, 18, 22, 23 дугаар цэцэрлэгүүд нормативаас хэтрүүлэн зарцуулжээ.....16-18 2.8. Хүнсний материалыг захиалгын дагуу бэлтгэж, их хэмжээгээр нөөцлөөгүй байна.....18-19 2.9. Тэтгэвэрт гарахад төрөөс олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг хуулийн дагуу олгожээ.....19 2.10. Тэтгэвэрт гарахад төрөөс олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг авсан 1 ажилтан төрийн албанаас чөлөөлөгдөөгүй байна ..... 19 2.11. Таван жил тутамд олгох мөнгөн тэтгэмжийг хуульд заасны дагуу олгосон байна ..... 19</p> <p><b>БҮЛЭГ-3</b></p> <p>3.1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, дүрэм, журмыг баримтлаагүй байна ..... 20</p>

“Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын  
2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн  
гүйцэтгэлийн аудитын тайлан

	3.2.Хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгээгүй байна .....20-21
	3.3. Өмч хамгаалах байнгын зөвлөл эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хүрээнд ажиллаж байна ..... 21
	3.4. Төсвийн хөрөнгөөр болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгийг тайланд бүрэн тусгажээ ..... 21-22
	3.5. Бүртгэлд тусгагдсан хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна ..... 22
	3.6. Мэргэжлийн байгууллагаас хийсэн зөвлөмж болон шалгалтын мөрөөр хийгдэж байгаа ажлууд үр нөлөөтэй хэрэгжиж байна ..... 22
	3.7. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна ..... 22
	<b>ДҮГНЭЛТ</b> .....23
	<b>ЗӨВЛӨМЖ</b> .....24

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>АДБОУС</b>	<b>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт</b>
<b>БСШУ</b>	<b>Боловсрол соёл шинжлэх ухаан</b>
<b>БСУГ</b>	<b>Боловсрол соёл урлагийн газар</b>
<b>ГА</b>	<b>Гүйцэтгэлийн аудит</b>
<b>ДАА</b>	<b>Дархан-Уул аймаг</b>
<b>ЗДТГ</b>	<b>Засаг даргын тамгын газар</b>
<b>ЕБС</b>	<b>Ерөнхий боловсролын сургууль</b>
<b>МУБИС</b>	<b>Монгол Улсын боловсролын их сургууль</b>
<b>НББ</b>	<b>Нягтлан бодох бүртгэл</b>
<b>НДШ</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэл</b>
<b>НХХ</b>	<b>Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн</b>
<b>ТБОНӨХБАУХА</b>	<b>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах</b>
<b>ТҮ</b>	<b>Төрийн үйлчилгээ</b>
<b>СӨБ</b>	<b>Сургуулийн өмнөх боловсрол</b>
<b>ХАБ</b>	<b>Хөдөлмөр аюулгүй байдал</b>
<b>ХХК</b>	<b>Хязгаарлагдмал хариуцлагатай компани</b>

## **АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ**

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

### **Аудитын зорилт**

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах асуудлаар аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Төсвийг бодитой төлөвлөж, санхүүжилт болон бусад орлогын эх үүсвэрийг бүрэн төвлөрүүлсэн эсэх
- Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх
- Худалдан авах үйл ажиллагаа, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, түүнд тавих хяналт үр нөлөөтэй байгаа эсэх

### **Хамарсан хүрээ**

Аудитад төрийн өмчийн 24, төрийн бус өмчийн 19 цэцэрлэг хамрагдахаас төрийн өмчийн 2, 9, 14, 16, 17, 19, 25 дугаар цэцэрлэгүүдийн 2017 оны үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас шалгалт хийгдсэн тул орхиж, бусад цэцэрлэгийг хамруулсан болно.

### **Үндсэн мэдээлэл**

“Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилгыг тодорхойлсон байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад 2017 онд улсын төсвөөс нийт 3,824,276.5 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсаныг бүрэн олгосон байна.

Мөн нэмэлт санхүүжилтийн дансаар 2017 онд 772.2 сая төгрөг зарцуулж, хөрөнгийн зарцуулалт урьд оноос 12 дахин өссөн байна.

### **Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, баримт материалуудад дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, давтан шалгах, нэгтгэх зэрэг арга

зүйг ашиглан, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### ***Шалгуур үзүүлэлт***

Аудитын зорилттой холбоотой дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

#### *Хуулиуд:*

- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- НББ-ийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХА тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт

#### *Засгийн газрын тогтоол:*

- Хоолны зардлын дундаж норматив батлах тухай
- Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай
- Төрийн өмчийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшил олгох журам
- ЕБС, цэцэрлэгийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт батлах тухай
- Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам

**БҮЛЭГ 1**

*Хандив, тусламжийн орлогын 35.6 хувийг төрийн сангийн дансанд байршуулалгүй зарцуулжээ.*

**НЭГ. АУДИТЫН ДҮН****1.1. Санхүүжих дундаж хүүхдийн тоо хүчин чадлаасаа харилцан адилгүй батлагдаж байна.**

2017 онд Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа СӨБ-ын байгууллагуудаас 7 дугаар цэцэрлэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамруулдаг тусгай ангийн 2 бүлэг, 15 дугаар цэцэрлэг 24 цагаар ажилладаг 1 бүлэг, 10 дугаар цэцэрлэг 24 цагаар ажилладаг 5 бүлэг, уртасгасан цагаар ажилладаг 2 бүлэг тус тус хичээллүүлдэг бөгөөд бусад 14 цэцэрлэг нь өдрийн ангиар үйл ажиллагаагаа явуулжээ.

Тус цэцэрлэгүүдийн дийлэнх нь төсвийн төсөлдөө санхүүжих дундаж хүүхдийн тоог тооцохдоо хүчин чадлаасаа 40-140 хүүхдээр илүүгээр тооцсон нь дараах хүснэгтээс харагдаж байна. Энэ нь хүүхдүүдийг аль болох цэцэрлэгт хамруулах, хүүхдийн тооны хэлбэлзэл их байдагтай холбоотой байна.

Цэцэрлэг	Санхүүжих дундаж хүүхдийн тоо				
	тусгай зөвшөөрлөөр	төсвийн төслөөр	батлагдсан төсвөөр	зөрүү	
				төсвийн төслөөс	батлагдсан төсвөөс
1 дүгээр цэцэрлэг	150	190	184	40	34
3 дугаар цэцэрлэг	200	270	230	70	30
4 дүгээр цэцэрлэг	280	405	334	125	54
5 дугаар цэцэрлэг	280	405	339	125	59
6 дугаар цэцэрлэг	200	150	193	(50)	(7)
7 дугаар цэцэрлэг	280	384	281	104	1
	24	24	10	-	(14)
8 дугаар цэцэрлэг	150	205	168	55	18
10 дугаар цэцэрлэг	280	250	195	(30)	(85)
11 дүгээр цэцэрлэг	100	150	99	50	(1)
12 дугаар цэцэрлэг	330	445	388	115	58
13 дугаар цэцэрлэг	385	385	322	-	(63)
15 дугаар цэцэрлэг	330	405	274	75	(56)
18 дугаар цэцэрлэг	280	375	300	95	20
21 дүгээр цэцэрлэг	280	375	270	95	(10)
22 дугаар цэцэрлэг	280	405	316	125	36
23 дугаар цэцэрлэг	190	330	230	140	40
24 дүгээр цэцэрлэг	100	150	97	50	(3)
<b>Дүн</b>	<b>4119</b>	<b>5303</b>	<b>4230</b>	<b>1184</b>	<b>111</b>

Харин батлагдсан төсөвт тусгагдсан хүүхдийн тоог хүчин чадалтай харьцуулан үзэхэд харилцан адилгүй байлаа. Тухайлбал 1, 3, 4, 5, 8, 12, 18, 22, 23

дугаар цэцэрлэгүүдийн хүүхдийн тоо хүчин чадлаасаа 30-59 хүүхдээр илүүтэйгээр батлагдсан бол 6, 7, 10, 13, 15, 21 дүгээр цэцэрлэгүүдийн хүүхдийн тоо хүчин чадлаасаа 7-85 хүүхдээр бага батлагдсан байна.

Цэцэрлэгүүдийн хамран сургах баг хорооны 2-5 насны хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамруулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Байгууллагын нэр	Хүчин чадал	Хамран сургах баг хорооны 2-5 насны хүүхдийн тоо	СӨБ-д хамрагдсан байдал	СӨБ-д хамрагдаагүй	Тухайн баг хорооныхоо цэцэрлэгт	Өөр баг хорооны цэцэрлэгт
1 дүгээр цэцэрлэг	150	1082	725	357	195	530
3 дугаар цэцэрлэг	200	790	416	374	255	161
4 дүгээр цэцэрлэг	280	530	476	54	286	190
5 дугаар цэцэрлэг	280	357	302	55	170	132
6 дугаар цэцэрлэг	200	574	341	233	267	74
7 дугаар цэцэрлэг	304	297	254	43	91	163
8 дугаар цэцэрлэг	150	389	205	184	187	18
10 дугаар цэцэрлэг	280	240	240	0	240	0
11 дүгээр цэцэрлэг	100	443	260	183	141	119
12 дугаар цэцэрлэг	330	547	451	96	282	169
13 дугаар цэцэрлэг	385	1159	477	682	415	62
15 дугаар цэцэрлэг	330	296	267	29	208	59
18 дугаар цэцэрлэг	280	220	220	0	172	48
21 дүгээр цэцэрлэг	280	436	395	41	294	101
22 дугаар цэцэрлэг	280	298	254	44	221	33
23 дугаар цэцэрлэг	190	687	303	384	287	16
24 дүгээр цэцэрлэг	100	737	510	227	307	203
<b>Дүн</b>	<b>4119</b>	<b>9082</b>	<b>6096</b>	<b>2986</b>	<b>4018</b>	<b>2078</b>

Дээрх хүснэгтээс харахад сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд нь ашиглавал зохих хүчин чадлаа 148.0 хувь буюу 1977 хүүхдээр хэтрүүлсэн байгаа нь тус аймагт цэцэрлэгийн хүрэлцээ муу байгааг харуулж байна.

Аймгийн хэмжээнд нийт хамран сургах баг хорооны 2-5 насны хүүхдийн 32.9 хувь буюу 2986 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байна.

### **1.2. Хувьсах зардлыг төсөвлөхдөө санхүүжих дундаж хүүхдийн тоонд тулгуурлан төлөвлөжээ.**

Аудитад хамрагдсан нийт цэцэрлэгүүд хувьсах зардлыг төсөвлөхдөө Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан итгэлцүүрийг үндэслэн санхүүжих дундаж хүүхдийн тоогоор тооцон гаргажээ. Мөн тус цэцэрлэгүүд нь хувьсах зардалдаа дээрх тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу цалин, НДШ, хичээл үйлдвэрлэлийн дадлага, бичиг хэрэг, ном хэвлэл, шуудан холбоо, интернетийн төлбөр, дотоод албан томилот, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс, нормын хувцас, зөөлөн эдлэл, эм бэлдмэл, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчийн устгал, ариутгал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зэргийг хувьсах зардалд оруулан тооцсон байна.



**1.3. Хоолны зардлыг Засгийн газраас баталсан дүнгээр тооцсон байна.**

Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор нэг хүүхдийн өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 1650 төгрөгөөр, 24 цагаар ажилладаг болон тусгай цэцэрлэгт 2400 төгрөгөөр тус тус тогтоосон.

Аудитад хамрагдсан цэцэрлэгүүд төсвийн төслийг боловсруулахдаа дээрх тогтоолыг баримтлан хоолны зардлыг зөв тооцсон байна.

**1.4. Хуульд заасан нэг удаагийн буцалтгүй тусламж, мөнгөн тэтгэмжийг холбогдох баримт бичгийг үндэслэн зөв төлөвлөсөн байна.**

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7-д зааснаар сум, тосгон, багийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, эмч, багш, туслах багш нарт 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж, Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоолоор Төрийн албаны тухай хуулийн 24.1.1, 24.1.2 дахь үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, тэтгэвэр тогтоолгож байгаа ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж олгохоор заасан.

Аудитад хамрагдсан цэцэрлэгүүд 2017 оны төсвийн төсөлдөө хөдөө орон нутагт ажилласан 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмжид 86 ажилтан албан хаагчийн 293,724.8 мянган төгрөгийг төсөвлөжээ.

Харин төрийн болон орон нутгийн өмчийн 25 ба түүнээс дээш жил ажилласан ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгоход олгох нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмжид 5 цэцэрлэгийн 8 албан хаагчийн 94,459.9 мянган төгрөгийг төсөвлөсөн байна.

Дээрх мөнгөн тэтгэмж, буцалтгүй тусламжийн тооцооллыг үнэн зөв хийсэн эсэхийг давтан тооцоолж тулгахад зөрүү илрээгүй болно.

**1.5. Санхүүжилт батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгогджээ.**

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад 2017 онд улсын төсвөөс 3,824,276.5 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсаныг бүрэн авчээ.

Санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу авч чадаж байгаа эсэхийг нягтлан бодогч нараас тодруулахад саадгүй, хугацаандаа бүрэн орж ирдэг гэсэн хариултыг өгч байлаа.

**1.6. Хандив, тусламжийн орлогын 35.6 хувийг төрийн сангийн дансанд байршуулалгүй зарцуулжээ.**

Энэхүү аудитын хүрээнд цэцэрлэг тус бүр дээр санал сэтгэгдлийг хүлээн авах хайрцаг ажиллуулж, эцэг эхчүүдээс судалгаа авсан бөгөөд нийт 1531 эцэг эх хамрагдлаа.

Бид уг судалгаагаар олж авсан мэдээллийг боловсруулах, нэгтгэн дүгнэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашигласан болно.

Судалгааны зорилго нь эцэг эхчүүд ямар ямар тусламж хандив авч байна, тус хандив нь хэдий хэмжээтэй, түүнийг бүртгэж тайлагнасан эсэх, зарцуулалтын

тайланг тавьдаг эсэх зэргийг тодорхойлоход чиглэгдсэн. Судалгааны үр дүн дараах байдалтай байна.

Асуулт	Хариулсан хүний тоо	Хувь
Хүүхдээ анх оруулахдаа хандив өгсөн	362	23.6
Хүүхдээ анх оруулахдаа хандив өгөөгүй	993	64.9
Хариулаагүй	176	11.5
Хандивын хэмжээ 100,000-аас доош төгрөгтэй тэнцэнэ	115	7.5
Хандивын хэмжээ 100,000-200,000 төгрөгтэй тэнцэнэ	113	7.4
Хандивын хэмжээ 200,000-аас дээш төгрөгтэй тэнцэнэ	128	8.3
Мөнгөөр илэрхийлэх боломжгүй	59	3.9
Хариулаагүй	1116	72.9
Хандивыг цэцэрлэгийн дансанд хийсэн	133	8.7
Бэлэн мөнгөөр өгсөн	206	13.5
Эд материалаар	76	5.0
Бусад хэлбэрээр	30	1.9
Хариулаагүй	1086	70.9
Хичээлийн жилийн явцад фондны мөнгө өгсөн	542	35.4
Фондны мөнгөнөөс гадна анги тохижилтод зориулж мөнгө өгсөн	411	26.8
Бусад үйл ажиллагаанд мөнгө өгсөн	177	11.6
Ямар нэгэн мөнгө өгөөгүй	347	22.7
Хариулаагүй	54	3.5
Хандивын зарцуулалттай холбоотой тайланг тавьдаг	591	38.6
Хандивын зарцуулалтын тайланг тавьдаггүй	327	21.4
Мэдэхгүй	134	8.7
Хариулаагүй	479	31.3

Судалгаагаар дараах төрлийн хандив, тусламжийг эцэг эхчүүдээс татан авчээ. Үүнд:

- Фондны мөнгө /анги бүр жилд харилцан адилгүй хураадаг бөгөөд ангийн засвар үйлчилгээ болон бусад шаардлагатай эд зүйлс зэрэгт зориулан зарцуулдаг/
- Тохижилтын мөнгө /хичээлийн жилийн төгсгөлд буюу 5 сарын сүүлээр БСШУ-ны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дүгээр тушаалаар баталсан цэцэрлэг хөгжүүлэх сангийн дүрмийн 1.3 дахь заалтыг үндэслэн хураан авч, чиглэгдсэн зорилтот ажилд зарцуулдаг/
- Хандивын мөнгө /хүүхдээ анх оруулахдаа өгсөн мөнгө/

Нийт судалгаанд хамрагдагсдын 27.1 хувь нь хүүхдээ цэцэрлэгт анх оруулахдаа хандивын мөнгө өгсөн гэж хариулсан бол тус мөнгийг цэцэрлэгийн дансанд байршуулсан гэж 8.7 хувь, бэлэн мөнгөөр өгсөн гэж 13.5 хувь, эд материалаар өгсөн гэж 5 хувь нь тус тус хариулсан байна.

Түүнчлэн нийт судалгаанд хамрагдагсдын 73.8 хувь нь хичээлийн жилийн явцад фондны мөнгө, ангийн тохижилтын мөнгө, бусад ямар нэгэн үйл ажиллагаанд зориулж мөнгө өгсөн гэж хариулснаас үзэхэд эцэг эхчүүдээс хандив мөнгө татдаг байдал ихээхэн байгааг харуулж байна.

Аудитад хамрагдсан цэцэрлэгүүдийн цуглуулсан хандив, түүнийг төрийн сангийн дансанд байршуулан зарцуулсан эсэхийг дараах хүснэгтээр харуулав.

**“Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын  
2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн  
гүйцэтгэлийн аудитын тайлан**

№	Байгууллагын нэр	Авсан хандив	Төрийн сангийн дансанд		Хөрөнгөөр
			төвлөрүүлсэн	төвлөрүүлээгүй	
1	1 дүгээр цэцэрлэг	8,712,900	3,970,000		4,742,900
2	3 дугаар цэцэрлэг	6,980,050	6,321,000	659,050	
3	4 дүгээр цэцэрлэг	8,178,125	3,669,060	4,509,065	
4	5 дугаар цэцэрлэг	8,076,000	3,943,000	4,133,000	
5	6 дугаар цэцэрлэг	4,159,490			4,159,490
6	7 дугаар цэцэрлэг	2,654,000		1,004,000	1,650,000
7	8 дугаар цэцэрлэг	2,032,000	835,000	1,197,000	
8	10 дугаар цэцэрлэг	21,417,350	13,200,000	8,217,350	
9	11 дүгээр цэцэрлэг	2,945,000		2,945,000	
10	12 дугаар цэцэрлэг	5,518,200	3,500,000	1,387,900	630,300
11	13 дугаар цэцэрлэг	11,077,500	10,559,500	518,000	
12	15 дугаар цэцэрлэг	20,070,000	20,070,000		
13	18 дугаар цэцэрлэг	6,802,750	3,542,000	2,900,750	360,000
14	21 дүгээр цэцэрлэг	3,006,700	1,206,000	1,541,700	259,000
15	22 дугаар цэцэрлэг	12,804,450	2,720,000	10,084,450	
16	23 дугаар цэцэрлэг				
17	24 дүгээр цэцэрлэг	8,386,600	235,000	8,151,600	
<b>ДҮН</b>		<b>132,821,115</b>	<b>73,770,560</b>	<b>47,248,865</b>	<b>11,801,690</b>

Дээрх хүснэгтээс харахад 23 дугаар цэцэрлэг ямар нэгэн хандив аваагүй, 6 дугаар цэцэрлэгт мөнгөөр хандив орж ирээгүй ба 1, 15 дугаар цэцэрлэгүүд хандив тусламжийн орлогыг төрийн сангийн дансанд байршуулан зарцуулжээ.

Харин бусад цэцэрлэгүүд нийт 47,248.9 мянган төгрөгийн хандивыг төрийн сангийн дансанд байршуулалгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь “Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5, 14.4.6 дахь “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ: бүх орлого, бүх зардал”, БСШУ-ны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дүгээр тушаалаар баталсан цэцэрлэг хөгжүүлэх сангийн дүрмийн 2.7 дахь “Төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн тухайд сангийн хөрөнгийг төрийн сангийн дансанд байршуулах” гэж заасныг тус тус зөрчиж байна.

Бүлгийн хуримтлалын мөнгө буюу фондны мөнгөний орлого, зарлагын баримтуудтай танилцаж, багш нарын гаргасан тайлан, анхан шатны баримтын бүрдлийг хянахад 4, 5, 6, 7, 10 дугаар цэцэрлэгүүдийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байсныг нөхөн бүрдүүллээ.

Хөрөнгөөр орж ирсэн хандивыг цэцэрлэгүүд бүртгэлд бүрэн тусгасан байв.

**БҮЛЭГ 2****Тушаал шийдвэргүйгээр нэмэгдэл хөлс олгох зөрчил  
ихээхэн байна.****2.1. Төрийн өмчит цэцэрлэгүүд мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдсан байна.**

Аудитад хамрагдсан байгууллагуудад бүлгийн 163, туслах 170 багш ажиллаж байна. Нийт багш нарын 0.6 хувь нь зөвлөх, 24.5 хувь нь тэргүүлэх, 31.9 хувь нь заах аргач зэрэгтэй байна.

Бүлгийн багш нар нь МУБИС-ийн сургуулийн өмнөх боловсролын багш, арга зүйч мэргэжил, Дархан дээд сургуулийг сургуулийн өмнөх боловсролын багш мэргэжлээр суралцаж төгсжээ. МУБИС-ийг төгссөн төгсөгчдийн мэргэжлийн дипломыг <http://mnue.mn/home/register/> цахим сайтаас шалгаж үзэхэд 4 дүгээр цэцэрлэгийн багш Х.Саранзаяа, А.Мөнхтуяа нарын мэдээлэл гарч ирээгүй болно. Иймд тус багш нарын мэргэжлийн диплом хүчин төгөлдөр эсэхэд лавлагаа авахаар МУБИС руу албан тоот явуулаад байна.

Туслах багш нар нь Дархан дээд сургуулийн туслах багшийн мэргэшил олгох курс, БСУГ-ын СӨБ-ын туслах багшийн мэргэшил олгох курсыг төгссөн мэргэшлийн үнэмлэхтэй байна.

Харин 7 дугаар цэцэрлэгийн эрхлэгч О.Энхжаргал нь сэтгүүлч мэргэжилтэй бөгөөд 2009 онд боловсрол судлалын магистр, 2015 онд сургуулийн өмнөх боловсролын багшийн бакалавр зэрэг авчээ. 2013 оноос тус цэцэрлэгийн эрхлэгчээр ажилласан. Цэцэрлэгийн эрхлэгчийн ажлын байрны тодорхойлолтод тавигдсан “СӨБ-ын байгууллагад 5-аас дээш жил ажилласан байх” гэсэн шалгуур үзүүлэлтийг хангаагүй байв.

**2.2. 5 ба 24 дүгээр цэцэрлэгээс бусад нь ажиллагсдын цалинг Засгийн газрын тогтоолд заасны дагуу тогтоож, олгосон байна.**

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын ихэнх нь ажилтнуудын үндсэн цалинг тогтоож, тооцож олгохдоо Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай”, 2014 оны 75 дугаар тогтоолоор баталсан “Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолуудыг мөрдөж ажиллажээ.

24 дүгээр цэцэрлэг орон тоо, цалинг шинэчлэн тогтоох тухай тушаал батлахдаа 7 хүний цалингийн сүлжээний шатлал болон цалингийн хэмжээг зөрүүлэн бичсэн, 3 дугаар цэцэрлэг 4 хүний албан тушаалын ангилал зэрэглэл цалингийн хэмжээг зөрүүтэй тогтоосон, 6 дугаар цэцэрлэгийн албан тушаалд томилсон тушаал нь аль албан тушаалд, ямар ангилал зэрэглэлээр цалинжуулах талаар тодорхой заагаагүй байгаа зэрэг нь дотоод хяналт болон хариуцлагагүй хандсаныг харуулж байна.

5 дугаар цэцэрлэг няравтаа албан тушаалын зэрэглэлийг ахиулан ТҮ-5-аар цалинжуулснаас 271.6 мянга, туслах багш Б.Уранчимэгийн цалингийн сүлжээний шатлалыг 20.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн олгосноос 247.3 мянган төгрөгийн цалин илүү олгосонд төлбөрийн акт тогтоож, аудитын явцад барагдуулав.

Мөн 24 дүгээр цэцэрлэг үйлчлэгчийг туслах багшийн цалингаар цалинжуулсанд 91.0 мянга, эмчид тушаал шийдвэргүйгээр цалин олгосон 326.1 мянга, нийт 417.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон болно.

Харин 22 дугаар цэцэрлэг багш Б.Буянхишиг, туслах багш Б.Цэрэндулам нарын албан тушаалын цалинг зөв тогтоосон боловч цалингийн сүлжээний шатлалыг бууруулан бодсоноос 304.9 мянган төгрөгийн цалинг нөхөн олгохоор төлбөрийн акт тавигдлаа.

Түүнчлэн Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д зааснаар төсвийн шууд захирагч нар батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан ажиллагсдын цалин хөлсийг тогтоох ёстой. Гэтэл 1, 3, 4, 7, 11, 13, 15, 18, 21 дүгээр цэцэрлэгүүд бичиг хэрэг, сантехникч, архив, угаагч, ахлах тогооч зэргийг батлагдаагүй орон тоонд ажил хавсруулан гүйцэтгүүлж, нийт 13,762.8 мянган төгрөгийг олгожээ.

### ***2.3. Удирдах ажилтнуудад тушаал шийдвэргүйгээр нэмэгдэл хөлс олгох зөрчил нийтлэг гарч байна.***

Засгийн газрын 2001 оны 90 дүгээр тогтоолд аймгийн төвийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багш нарт 8-10 хувийн цалингийн нэмэгдэл, Засгийн газрын 2007 оны 219 дүгээр тогтоолд заах аргач, тэргүүлэх, зөвлөх зэрэгтэй багш нарт 10-20 хувийн мэргэшлийн зэрэг олгохоор тусгагджээ.

Эдгээр нэмэгдлийг дээрх тогтоолуудад заасан ажиллагсад бүрэн авч байна.

Харин БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 362/112/183 дугаар хамтарсан тушаалаар баталсан цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багшид ур чадварын нэмэгдэл олгох журмыг төдийлөн хэрэгжүүлээгүй байв.

Цэцэрлэгийн эрхлэгч нарын ажлыг аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс үнэлэн аймгийн Засаг даргын захирамжаар ур чадварын нэмэгдлийг олгож байна. Гэвч 2017 оны сүүлийн хагас жилийн ур чадварын нэмэгдлийг олгох шийдвэр гараагүй байхад 1, 6, 7, 11, 13, 15, 21, 22, 24 дүгээр цэцэрлэгүүд ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр авчээ. Энэ нь дээрх журмын 10 дахь “цэцэрлэгийн эрхлэгчид ур чадварын нэмэгдлийг олгох, олгож байгаа нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах, хасах асуудлыг аймгийн БСУГ-ын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн захирал, эрхлэгчийг томилсон этгээдийн шийдвэрээр шийдвэрлэнэ” гэж заасныг зөрчиж байна. Аймгийн Засаг дарга тус шийдвэрийг 2018 онд нөхөн гаргасан ба 2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар дотоод хяналтыг сайжруулж, дээрх алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн болно.

Харин арга зүйч, багш, туслах багшид ур чадварын нэмэгдлийг ажил мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцож, амжилт гаргасан, сургалтын орчинг

тохижуулсан зэрэг тохиолдолд тухайн сард нь, эсвэл жилийн эцсээр төсөв хүрэлцвэл ур чадварын нэмэгдэл олгодог байна.

Зарим цэцэрлэгүүд гүйцэтгэх болон үйлчилгээний ажилтнуудад тогтмол хэмжээгээр ажлын үзүүлэлтийг тооцолгүйгээр олгож байна. Тухайлбал: 4 дүгээр цэцэрлэг арга зүйч, хөгжмийн багш, нягтлан бодогч, нярав нарт, 12 дугаар цэцэрлэг нягтлан бодогч, нярав, манаач нарт, 13 дугаар цэцэрлэг арга зүйч, нягтлан бодогч, нярав нарт, 18 дугаар цэцэрлэг нягтлан бодогч, тогооч, үйлчлэгч нарт, 21 дүгээр цэцэрлэг нягтлан бодогч, нярав нарт ажлын үзүүлэлтийг дүгнэлгүйгээр сар бүр ур чадварын нэмэгдэл тогтмол олгожээ.

Энэ нь Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4-т “Ур чадварын нэмэгдлийг олгох, олгож байгаа нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах, хасах асуудлыг энэ журмын 2, 8-д заасан шалгуурыг үндэслэн тухайн байгууллагын эрх баригчийн тушаалаар шийдвэрлэнэ”, БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын 2010 оны 362/112/183 дугаар хамтарсан тушаалын 9-д “Ерөнхий боловсролын сургуулийн багш, сургалтын менежер, нийгмийн ажилтан, цэцэрлэгийн багш, туслах багш, арга зүйчид ур чадварын нэмэгдэл олгох, олгож байгаа нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах, хасах асуудлыг ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн тухайн байгууллагын ерөнхий менежерийн тушаалаар шийдвэрлэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Түүнчлэн зарим цэцэрлэгүүд, тодруулбал 1, 11 дүгээр цэцэрлэг архив, бичиг хэрэг, ХАБ, сантехник хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг орон тоо хэтэрсэн харагдуулахгүйн тулд ур чадварын нэмэгдэл нэрээр тайлагнаж байна.

Ур чадварын нэмэгдлийн төсвийн төслөөрх дүнг гүйцэтгэлтэй харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

Ажиллагсад	Эзэлж буй хувь хэмжээ		
	Төсвийн төслөөр	Гүйцэтгэлээр	Зөрүү
Эрхлэгч	9.8	24.2	14.4
Багш, туслах багш, арга зүйч	53.7	31.8	(21.9)
Нягтлан бодогч, нярав	12.7	30.9	18.2
Бусад ажиллагсад	23.8	13.1	(10.7)
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>0.0</b>

Дээрх хүснэгтээс харахад төсвийн төсөлд тооцсон дүнгээс эрхлэгч болон нягтлан бодогч, няравууд ур чадварын нэмэгдлийг илүүтэй авдаг байна. Иймд цаашид дээрх нэмэгдлийг ажиллагсдад тэгш хүртээмжтэй олгоход анхаарах нь зүйтэй байна.

Засгийн газрын 2013 оны 393 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшил олгох” журмыг баталсан.

Ажилтнуудад үр дүнгийн урамшлыг олгохдоо ажилтан тус бүрийн ажлыг шалгуур үзүүлэлтээр үнэлэн, журамд заасан хувь хэмжээгээр олгосон байна.

Харин дээд шатны төсвийн захирагчийн тушаал шийдвэр, эрхийн актгүйгээр үр дүнгийн урамшил, ур чадварын нэмэгдэл олгох байдал цэцэрлэгүүдэд түгээмэл гарсан тул төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Ур чадварын нэмэгдэл	Үр дүнгийн урамшил	Нийт	Үүнээс: удирдах албан тушаалтанд
1	3 дугаар цэцэрлэг	384.7	229.9	<b>614.6</b>	614.6
2	4 дүгээр цэцэрлэг	106.7	263.1	<b>369.8</b>	369.8
3	6 дугаар цэцэрлэг	505.6	288.5	<b>794.1</b>	288.5
4	7 дугаар цэцэрлэг	264.0	288.3	<b>552.3</b>	552.3
5	8 дугаар цэцэрлэг	323.7	-	<b>323.7</b>	-
6	10 дугаар цэцэрлэг	305.9	426.7	<b>732.6</b>	732.6
7	11 дүгээр цэцэрлэг	-	245.8	<b>245.8</b>	245.8
8	12 дугаар цэцэрлэг	191.3	-	<b>191.3</b>	-
9	13 дугаар цэцэрлэг	128.3	213.4	<b>341.7</b>	341.7
10	18 дугаар цэцэрлэг	-	320.1	<b>320.1</b>	320.1
11	21 дүгээр цэцэрлэг	-	303.4	<b>303.4</b>	303.4
12	22 дугаар цэцэрлэг	-	259.2	<b>259.2</b>	259.2
<b>ДҮН</b>		<b>2,210.2</b>	<b>2,838.4</b>	<b>5,048.6</b>	<b>4,028.0</b>

Цэцэрлэгүүд тушаал шийдвэргүйгээр ур чадвар, үр дүнгийн урамшилд нийт 5,048.6 мянган төгрөг олгосноос 79.8 хувь буюу 4,028.0 мянган төгрөгийг удирдах албан тушаалтнуудад олгожээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн цалин, хөлс болон нэмэгдэл урамшил зардлын бүлэгт унаа хоолны хөнгөлөлт батлагдаагүй байхад 10 дугаар цэцэрлэг 365.5 мянга, 18 дугаар цэцэрлэг 720.0 мянган төгрөг тус тус олгосон байлаа. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “*батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*” гэж заасныг мөрдөж ажиллаагүй тул санхүүгийн тайлангийн аудитаар 10 цэцэрлэгт гарсан зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна. Харин 18 дугаар цэцэрлэгт гарсан зөрчлийг цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж өглөө.

#### **2.4. Зарим цэцэрлэгүүдийн удирдах болон санхүүгийн ажилтнуудын цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулан олгосон байна.**

Багш, туслах багш болон бусад үйлчилгээний ажилтнуудын ээлжийн амралтын олговрыг тооцож олгохдоо Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасан амралтын хоногийг баримталж ажилласан боловч цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогчид цалин ээлжийн амралтын олговрыг давхардуулан тооцож олгосон зөрчил илэрлээ. Үүнд: 13 дугаар цэцэрлэгийн эрхлэгч С.Жаргалмаад 4 хоногийн цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулан тооцож 191.7 мянган төгрөг, 21 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Ш.Ундармаад 2 хоногийн, нягтлан бодогч Б.Нармандахад 7 хоногийн цалин, ээлжийн амралтыг тус давхардуулан тооцож нийт 334.0 төгрөг олгосон тул төлбөрийн акт тогтоолоо.

Мөн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Д.Эрдэнэчимэг, 4 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Д.Гэрэлт-Од, нягтлан бодогч Ш.Замбалтуяа, нярав Г.Энхцэцэг, 10 дугаар цэцэрлэгийн эрхлэгч С.Алтанчимэг, нягтлан бодогч Ж.Эрдэнэсанаа, 23 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Н.Тунгалагт цалин, ээлжийн амралтыг давхардуулан тооцож нийт 2,072.9 мянган төгрөг олгосныг буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосныг холбогдох байгууллагууд хэрэгжүүлж ажилласан байна.

Бусад төрийн өмчит цэцэрлэгүүдийн ээлжийн амралтын хуваарь баталсан тушаалыг хуулиар зааж өгсөн ээлжийн амралтын хугацаа болон цалингийн тооцооны хүснэгттэй тулгахад зөрүү гараагүй болно.

**2.5. Шүүхийн шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны цалинд 5,204.0 мянган төгрөгийг нөхөн олгожээ.**

23 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Н.Тунгалаг нь аймгийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Б/34 тоот захирамжаар ажлаас чөлөөлөгдсөн ба Дархан-Уул аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 1025 дугаар шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалин 1,340.1 мянган төгрөгийг нөхөн авчээ.

11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчийн 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/17 тоот тушаалаар манаач Б.Сүнжидмааг ажлаас чөлөөлж, 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 001/ХТ2017/01048 дугаар тогтоолыг үндэслэн ажилд нь эгүүлэн томилж, ажилгүй байх хугацааны цалинд 2,090.9 мянган төгрөгийг төсвөөс олгожээ. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлүүлэхээр төлбөрийн акт тавигдсан болно.

Мөн 3 дугаар цэцэрлэг ажлаас халагдсан багш Л.Одгэрэлд ажилгүй байсан хугацааны цалинд 2,399.7 мянган төгрөг төсвөөс олгосныг 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар буруутай этгээдээр төлүүлэхээр албан шаардлага хүргүүлснийг хугацаанд нь биелүүлж ажилласан байв.

Бусад цэцэрлэгүүд ажлаас халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгоход хөрөнгө зарцуулаагүй байна.

**2.6. Зарим цэцэрлэгийн бэлтгэсэн хүнсний материалын үнэ зах зээлийн үнээс өндөр байна.**

Төрийн өмчит цэцэрлэгүүд 2017 онд нийт 1,364,223.4 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn) сайтаас гол нэр төрлийн хүнсний материалын зах зээлийн үнийг худалдан авсан үнэтэй харьцуулан шалгахад 1, 8, 13, 15, 22 дугаар цэцэрлэгүүд зах зээлийн үнээс өндрөөр бэлтгээгүй байв. 1 дүгээр цэцэрлэг 7 хоног бүрийн зах зээлийн үнийг дээрх сайтаас авч ажлын баримтдаа хавсаргасан нь аудитын ажлыг хөнгөвчилсөн сайшаалтай үйл ажиллагаа байлаа.



Харин зах зээлийн үнээс өндрөөр бэлтгэсэн үнийн зөрүүд 5 дугаар цэцэрлэгт 559.0 мянга, 13 дугаар цэцэрлэгт 210.1 мянга, 21 дүгээр цэцэрлэгт 375.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 5 дугаар цэцэрлэг аудитын явцад төлбөрийг барагдуулав.

4 дүгээр цэцэрлэг гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн худалдан авахдаа нийт 1,592.6 мянган төгрөгөөр зах зээлийн үнээс илүү үнээр бэлтгэсэн бөгөөд энэ нь эхний хагас жилд “Номин тав трейд” ХХК-тай гэрээний дагуу хийсэн худалдан авалт байлаа. Холбогдох хүмүүст цаашид Үндэсний статистикийн хорооноос гаргасан гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үнийг харгалзан худалдан авалт хийх талаар зөвлөмж өглөө.

Мөн цэцэрлэгүүдийн шингэн сүүний худалдан авалт зарим саруудад зах зээлийн үнээс өндрөөр бэлтгэгдсэн бөгөөд энэ нь их хэмжээний сүүг нийлүүлэх нийлүүлэгч тэр бүр олддоггүйтэй холбоотой учраас төлбөрийн акт тавилгүй орхисон болно.

**2.7. Хоолны зардлыг 4, 7, 18, 22, 23 дугаар цэцэрлэгүүд нормативаас хэтрүүлэн зарцуулжээ.**

Төрийн өмчит цэцэрлэгүүдэд 2017 онд 1,363,510.6 мянган төгрөгийн хоолны зардал батлагдсанаас зарцуулалт нь 70,281.8 мянган төгрөгөөр илүү буюу 1,433,792.4 мянган төгрөг байв. Энэ нь 126,679.7 мянган төгрөгийн хүнсний материалын оны эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Харин Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор “Хоолны зардлын дундаж норматив” баталсан дүнтэй тулган шалгахад дараах байдалтай байна.

Цэцэрлэг	Нэг өдрийн хоолны зардал			Нийт хоолны зардал		
	нормоор	гүйц-ээр	Зөрүү	нормоор	гүйц-ээр	Зөрүү
1 дүгээр цэцэрлэг	1650	1650	-	59,187.2	59,187.2	0.0
3 дугаар цэцэрлэг	1650	1653	(3)	73,862.3	73,992.5	130.3
4 дүгээр цэцэрлэг	1650	1657	(7)	107,672.4	108,142.7	470.3
5 дугаар цэцэрлэг	1650	1639	11	108,464.4	107,713.3	(751.1)
6 дугаар цэцэрлэг	1650	1609	41	74,923.2	73,080.7	(1,842.5)
7 дугаар цэцэрлэг	1650	1684	(34)	92,698.7	94,619.4	1,920.8
	2400	2164	236	8,092.8	7,298.2	(794.6)
8 дугаар цэцэрлэг	1650	1654	(4)	53,144.9	53,269.4	124.6
10 дугаар цэцэрлэг	1650	1640	10	11,385.0	11,315.9	(69.1)
	2400	2245	155	86,628.0	81,016.4	(5,611.6)
11 дүгээр цэцэрлэг	1650	1630	20	34,831.5	34,408.7	(422.8)
12 дугаар цэцэрлэг	1650	1646	4	122,001.0	121,741.9	(259.1)
13 дугаар цэцэрлэг	1650	1630	20	110,163.9	108,838.7	(1,325.2)
15 дугаар цэцэрлэг	1650	1461	189	91,281.3	80,815.2	(10,466.1)
	2400	2208	192	13,276.8	12,217.1	(1,059.7)
18 дугаар цэцэрлэг	1650	1682	(32)	97,449.0	99,331.7	1,882.7
21 дүгээр цэцэрлэг	1650	1603	47	94,452.6	91,770.2	(2,682.4)
22 дугаар цэцэрлэг	1650	1656	(6)	103,570.5	103,944.2	373.7
23 дугаар цэцэрлэг	1650	1843	(193)	71,336.1	79,661.2	8,325.1
24 дүгээр цэцэрлэг	1650	1648	2	31,468.8	31,427.8	(41.0)
<b>Дүн</b>				<b>1,445,890.2</b>	<b>1,433,792.4</b>	<b>(12,097.8)</b>

Дээрх тогтоолыг мөрдөж ажиллаагүйгээс хоолны зардлын дундаж нормативыг 3, 4, 7, 8, 18, 22, 23 дугаар цэцэрлэгүүд 124.6-8,325.1 мянган төгрөгөөр хэтрүүлсэн бол 5, 6, 10, 11, 12, 13, 15, 21 дүгээр цэцэрлэгүүд 259.1-11,525.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Тухайлбал:

- 18 дугаар цэцэрлэг нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 32 төгрөгөөр хэтрүүлснээс 1,882.7 мянга,
- 23 дугаар цэцэрлэг нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 193 төгрөгөөр хэтрүүлснээс 8,325.1 мянга,
- 7 дугаар цэцэрлэг тусгай ангийн нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 236 төгрөгөөр дутуу зарцуулснаас 794.6 мянган төгрөг хэмнэсэн бол өдрийн ангийн нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 34 төгрөгөөр хэтрүүлж 1,920.7 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

Хоолны зардлын батлагдсан төсөв тайлант онд хэтрээгүй бөгөөд оны эхний үлдэгдлээс 18 дугаар цэцэрлэг 4,818.3 мянга, 23 дугаар цэцэрлэг 5,875.5 мянга, 7 дугаар цэцэрлэг 9,181.1 мянган төгрөг тус тус зарцуулсан нь нэг хүүхдэд ногдох хоолны зардлын норматив хэтрэхэд нөлөөлжээ.

Дараах цэцэрлэгүүдийн хоолны зардлын гүйцэтгэл батлагдсан нормативт хүрэхгүй байна. Тухайлбал:

- 10 дугаар цэцэрлэг 24 цагийн ангийн нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 155 төгрөгөөр дутуу зарцуулж, нийт 5,611.6 мянга,
- 21 дүгээр цэцэрлэг нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 47 төгрөгөөр дутуу зарцуулж, нийт 2,682.4 мянга,
- 6 дугаар цэцэрлэг нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 41 төгрөгөөр дутуу зарцуулж, нийт 1,842.5 мянга,
- 15 дугаар нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг өдрийн ангид 189, 24 цагийн ангид 192 төгрөгөөр дутуу зарцуулж, нийт 11,525.9 мянга,
- 13 дугаар цэцэрлэг нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 20 төгрөгөөр дутуу зарцуулж, нийт 1,325.2 мянган төгрөгөөр хоолны зардлын нормативаас бага байна.

Цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоог батлагдсан төлөвлөгөөнөөс 6 дугаар цэцэрлэг 49 хүүхдээр, 21 дүгээр цэцэрлэг 36 хүүхдээр, 15 дугаар цэцэрлэг 58 хүүхдээр, 13 дугаар цэцэрлэг 33 хүүхдээр тус тус хэтрүүлсэн нь хоолны зардлын гүйцэтгэл нормативаас бага зарцуулахад хүргэжээ.

Харин 10 дугаар цэцэрлэгийн хоол, хүнсний зардал уртасгасан болон 24 цагийн ажиллагаатай 7 бүлгээр тооцож батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр эхний хагас жилд батлагдсан төлөвлөгөөний дагуу сүүлийн хагас жилд ердийн бүлгийг нэгээр нэмэгдүүлж, уртасгасан цагийн ажиллагаатай 2 бүлгийг ердийн бүлэг болгон зохион байгуулсантай холбоотой байна.

Түүнчлэн гүйцэтгэлээр зарцуулсан хоолны зардлыг бүлгийн ирцийн бүртгэлтэй тулгахад 6 дугаар цэцэрлэг 59 хүүхдээр зөрүүтэй тайлагнаж 96.2 мянган төгрөг хий нэмэгдүүлэн зарлага гаргасан, 4 дүгээр цэцэрлэг 255.6 мянган төгрөгийн хүнсний материалыг орлогод аваагүй зарлага гаргасан нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байсан тул төлбөрийн акт тогтоов.

Батлагдсан төсөвт зардлаас аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн газартай хамтран 0-5 насны эмнэлгийн хяналтанд байдаг суурь өвчтэй хүүхдийг эрүүлжүүлэхүй сувиллын үйл ажиллагаанд 6 дугаар цэцэрлэг нийт 765.0 мянган төгрөг, 18 дугаар цэцэрлэг 423.1 мянган төгрөг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “*батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Төсвийн шууд захирагчид Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлжээ.

Аудитаар хүүхдийн хоолны өдөрлөгт бүртгэсэн хүүхдийн тоог багшийн журналын ирцтэй, зарцуулсан хоолны тооцоог нярвын тайлангаарх зарлагатай, хоолны дээжийн бүртгэлийг хоолны цэс, өдөрлөг, нярвын олгосон хүнсний материалтай, хүнсний материалын орлого, зарлагын журналыг нярвын тайлантай тус тус тулган шалгав.

Тулгалтаар 23 дугаар цэцэрлэгийн хоолны өдөрлөг, багшийн журнал болон ирцийн нэгтгэл, хүнсний зарлагын тайлан дээрх хүүхдийн тоонууд ихээхэн зөрүүтэй, 15, 22 дугаар цэцэрлэгүүдийн хүүхдийн хоолны өдөрлөгийн дүн ихээхэн засвартай байлаа.

24 дүгээр цэцэрлэгийн хоолны материалын анхан шатны баримт бүрдүүлэлт, эмх цэгц бусад цэцэрлэгүүдээс илүү сайн байлаа. Түүнчлэн орлого зарлагаа товчоолон гаргадаг нь аудитыг гүйцэтгэхэд дөхөмтэй байв.

Мөн хувийн хэвшлийн цэцэрлэгүүдэд олгосон санхүүжилтийг анхан шатны баримтуудтай тулган шалгалаа. Тулгалтаар Цоглог жаалууд 2,374.5 мянга, Өсөх нахиа 11,763.2 мянга, Сүмдарьцэцэг 5,536.3 мянга, Бурхантын жаргалант өргөө 9,030.3 мянга, нийт 28,704.3 мянган төгрөгийн санхүүжилт илүү авсныг тогтоож, төлбөрийн акт тавилаа. Энэхүү зөрчил нь Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан “**Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал**”-ын 3.12 дахь “*Сургалтын нормативт зардлын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу сар тутам олгоно*” гэсэн заалтыг аймгийн БСУГ хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

## **2.8. Хүнсний материалыг захиалгын дагуу бэлтгэж, их хэмжээгээр нөөцлөөгүй байна.**

Аудитад хамрагдсан байгууллагуудын хүнсний материалын 2017 оны эхний үлдэгдэл 126,679.7 мянган төгрөг байснаас оны эцэст 55,432.1 мянган төгрөг болж, оны эхнээс 71,247.6 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь хүүхдийн тоог батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэн авсантай холбоотой. Оны эхэн ба эцэст үлдэгдэлтэй хүнсний материалын орлого, зарлагын гүйлгээг хөөн шалгахад эргэлтэнд ороогүй материал байгаагүй тул хүнсний материалыг их хэмжээгээр нөөцлөөгүй гэж үзлээ.

Аудитын явцад агуулахад байсан хүнсний материалын үлдэгдлийг тоолоход 3 дугаар цэцэрлэгт 78.6 мянга, 12 дугаар цэцэрлэгт 95.9 мянга, нийт 174.5 мянган төгрөгийн материал дутагдсан тул төлбөрийн акт тогтоосноос 12 дугаар цэцэрлэг аудитын явцад барагдуулав.

**2.9. Тэтгэвэрт гарахад төрөөс олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг хуулийн дагуу олгожээ.**

Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоолоор Төрийн албаны тухай хуулийн 24.1.1, 24.1.2 дахь үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, тэтгэвэр тогтоолгож байгаа ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж олгохоор заасан.

Дархан-Уул аймгийн төрийн өмчит цэцэрлэгүүдээс 2017 онд 8 хүн тэтгэвэр тогтоолгон, 94,154.0 мянган төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг авч, ажлаас чөлөөлөгджээ.

Тэтгэмж тооцож олгосон хугацааг ажилтны хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэртэй тулгахад ажилласан жилд зөрүү гараагүй болно. Мөн тэтгэмжийн хэмжээг тооцохдоо хамгийн сүүлд хашиж байсан албан тушаалын нэг сарын үндсэн цалингийн хэмжээг сүүлийн 3 жилийн дунджаар тооцсон эсэхийг тулган шалгахад тохирч байв.

**2.10. Тэтгэвэрт гарахад төрөөс олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг авсан 1 ажилтан төрийн албанаас чөлөөлөгдөөгүй байна.**

23 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Н.Тунгалаг 2015 онд дээрх тэтгэмжийг авсан боловч одоог хүртэл ажиллаж байгаад 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлснийг биелүүлээгүй байна.

**2.11. Таван жил тутамд олгох мөнгөн тэтгэмжийг хуульд заасны дагуу олгосон байна.**

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7-д зааснаар сум, тосгон, багийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, эмч, багш, туслах багш нарт 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгохоор хуульчилсан.

Дархан-Уул аймгийн төрийн өмчит цэцэрлэгүүдийн 84 албан хаагчид 2017 онд нийт 281,279.7 мянган төгрөгийг дээрх хуулийн дагуу хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх мөнгөн тэтгэмжээр олгосон байна.

Ажилласан хугацааг нийгмийн даатгалын дэвтрээс хөөн шалгасан ба тооцооллыг тулган шалгахад зөрүү илрээгүй болно.

**БҮЛЭГ 3**

*Хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих хяналт үр нөлөөтэй байгаа боловч худалдан авах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулахгүй байна.*

**3.1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, дүрэм, журмыг баримтлаагүй байна.**

Аудитад хамрагдсан байгууллагууд тайлант онд хоол, хүнсний материал бэлтгэхэд 30,526.0-121,702.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн бөгөөд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийг баримтлаагүй байна.

Хэдийгээр хүнсний материал худалдан авахдаа бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулж, гэрээг дүгнэж байгаа боловч гэрээнд бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүн, нийлүүлэх хугацааг тодорхой заагаагүй, гэрээ дүгнэсэн актад нийт нийлүүлсэн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээ, үнэ болон нийлүүлэлтийн хугацааг баримталсан эсэхийг дурьдалгүйгээр нэг хэвийн загвараар гэрээ байгуулж, биелэлтийг дүгнэж байна. Түүнчлэн хүнсний бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн цөөн тооны бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулсан атлаа өөр иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авалт хийх зөрчил бүх цэцэрлэгүүдэд нийтлэг байлаа.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа бүтээгдэхүүний үнийн харьцуулалт хийгээгүйгээс зах зээлийн үнээс өндрөөр худалдан авалт хийх, батлагдсан норм, нормативыг зөрчих, чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн нийлүүлэгдэх эрсдэлтэй.

**3.2. Хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгээгүй байна.**

Аудитын явцад цэцэрлэгүүдийн агуулах складын үлдэгдэл, эд хөрөнгийн ашиглалтын карт, нярвын тайлан болон санхүүгийн тайлан дахь хөрөнгийн үлдэгдлүүдийг тулган шалгахад 6 дугаар цэцэрлэгт 8,950.8 мянга, 18 дугаар цэцэрлэгт 5,375.2 мянга, нийт 14,326.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж ашиглагдахгүй, агуулахад хадгалагдаж байна.

6 дугаар цэцэрлэгийн “Энэрэл цогцолбор” сургуулийн байранд ажиллаж байгаа салбар цэцэрлэгийн цахилгаан пийшин эвдэрснээс цайны газар бүрэн зогсож, гал тогооны бусад 8 төрлийн тоног төхөөрөмжүүд ашиглагдахгүй байна. Эдгээр тоног төхөөрөмжийн 2,685.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 118.8 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авч, 6,147.0 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн БСГ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгүүд байв.

18 дугаар цэцэрлэгт ашиглах боломжгүй, ашиглалтын хугацаа дуусаагүй 1 болон 2 дугаар хоолны тогоог БСГ-аас ирүүлсэн нь чанарын шаардлага хангахгүй

болох нь мэргэжлийн байгууллагаас тогтоосон тул зориулалтаар нь ашиглаагүй байна.

Бусад цэцэрлэгүүдийн хувьд илүүдэлтэй, хэрэгцээ шаардлагагүй, хугацаа хэтэрсэн болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгө байгаагүй болно.

Ашиглалтын хугацаа дуусч, өртгөө бүрэн нөхсөн хөрөнгө болон илүүдэлтэй хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн хорооны 2009 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газарт санал хүргүүлэн шийдвэрлүүлж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### **3.3. Өмч хамгаалах байнгын зөвлөл эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хүрээнд ажиллаж байна.**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу аудитад хамрагдсан бүх цэцэрлэгүүд төсвийн шууд захирагчийн шийдвэрээр өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулжээ.

Мөн өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилж, тус хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана” гэж заасны дагуу тооллого явуулж, тооллогын дүн, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, саналыг үндэслэн эд хөрөнгө актлах саналаа аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн, гарсан шийдвэрийн хүрээнд ажлыг зохион байгуулж байна.

Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу хөрөнгө акталж устгах, шилжүүлэх ажлыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүд зохион байгуулж, ажлын тайлан, холбогдох баримт бичгийг байгууллагын удирдлагад тайлагнан ажилласан байна.

### **3.4. Төсвийн хөрөнгөөр болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгийг тайланд бүрэн тусгажээ.**

Аудитад хамрагдсан байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайланд нийт 342,671.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс 30,591.3 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 163,961.8 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар, 112,468.1 мянган төгрөгийн хөрөнгийг гадаадын зээл тусламжаар, 15,179.0 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр, 10,747.9 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн, 9,723.4 мянган төгрөгийн хөрөнгийг бусад эх үүсвэрээр авчээ.

Нийт нэмэгдсэн хөрөнгийн 47.8 хувийг хандивын хөрөнгө эзэлж байгаагаас харахад цэцэрлэгүүдийн хувьд хандив тусламж их байдаг байна.

Нэмэгдсэн хөрөнгүүдийг анхан шатны баримт, үндсэн хөрөнгийн журнал, ерөнхий дэвтэр, дэлгэрэнгүй бүртгэл, санхүүгийн байдлын тайлантай тулган шалгахад бүртгэлгүй орхигдуулсан хөрөнгө байхгүй байв. Гүйцэтгэлийн аудитаарх

үндсэн хөрөнгийн дүн санхүүгийн аудитаар баталгаажуулсан дүнтэй тохирч байлаа.

**3.5. Бүртгэлд тусгагдсан хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.**

Цэцэрлэгүүдийн санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгүүдийг байгууллага тус бүрээр явж, зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг тулган шалгахад ашиглагдаагүй буюу зориулалт бусаар ашиглагдсан хөрөнгөгүй байна.

**3.6. Мэргэжлийн байгууллагаас хийсэн зөвлөмж болон шалгалтын мөрөөр хийгдэж байгаа ажлууд үр нөлөөтэй хэрэгжиж байна.**

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газраас сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн. Тус аудитаар нийт 375,761.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 86,217.4 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 266,902.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 4.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 18.6 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар тушаал шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэл олгосон, хөрөнгийг шууд зардлаар тайлагнасан, орлогыг илүү бүртгэсэн, санхүүгийн тайлангийн уялдаа холбоо хангалтгүй, үндсэн хөрөнгийн элэгдлийг буруу тооцсон, цалин ээлжийн амралтын олговрыг давхардуулан авсан, хөрөнгийг ангилал зөрүүлэн бүртгэсэн, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал олгосон зэрэг алдаа зөрчлүүд нийтлэг илэрчээ.

Аудитын явцад төлбөрийн актын барагдуулалт, албан шаардлагын биелэлт болон зөвлөмжийн хэрэгжилттэй танилцахад акт, албан шаардлага 100.0 хувийн, зөвлөмж 87.5 хувийн биелэлттэй байна.

Өгөгдсөн зөвлөмжүүдээс элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, хэвийн ашиглагдаж байгаа гадна хашаа, хүүхдийн тоглоомын талбай, компьютер тоног төхөөрөмж зэрэг хөрөнгүүдийг дахин үнэлж, ашиглалтын хугацааг тооцох гэсэн 5 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

**3.7. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2017 оны байдалд Төрийн аудитын газар болон аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалтуудыг хийсэн байна.

Санхүүгийн хяналт аудитын албаны шалгалтаар уг хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг байршуулахдаа хугацаа хоцроосон, тайлан илгээгээгүй зэрэг зөрчилд 20 цэцэрлэгийн төсвийн шууд захирагч нарт аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/419 тоот захирамжаар 1 сарын үндсэн цалингийн 10 хувиар сахилгын шийтгэл ногдуулжээ. Үүнд 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 13, 16, 17, 18, 19, 21, 22, 23, 24, 25 дугаар цэцэрлэгүүд дээрх зөрчлийг гаргасан ба төрийн өмчит цэцэрлэгийн 83.3 хувь нь байна.

Харин Төрийн аудитын газраас хийгдсэн нийцлийн аудитаар 25 дугаар цэцэрлэг 101.5 сая төгрөгийн 5 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байсныг засуулахаар албан шаардлага хүргүүлэн ажиллажээ. Бусад цэцэрлэгүүдэд зөрчил илрээгүй байна.

### **ХОЁР. АУДИТЫН ДҮГНЭЛТ**

Аудитаар нийт 92,476.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, үүнээс 39,790.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тавигдаж, 8,325.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 44,361.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Санхүүжих дундаж хүүхдийн тоо хүчин чадлаасаа харилцан адилгүй батлагдаж байна.
2. Төсвийн төлөвлөлт хийхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталсан байна.
3. Хандив, тусламжийн орлогын 35.6 хувийг төрийн сангийн дансанд байршуулалгүй зарцуулжээ.
4. Төрийн өмчит цэцэрлэгүүд мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдсан байна.
5. Удирдах ажилтнуудад тушаал шийдвэргүйгээр нэмэгдэл хөлс олгох зөрчил нийтлэг гарч байна.
6. Зарим цэцэрлэгүүд хоолны зардлыг нормативаас хэтрүүлэн зарцуулжээ.
7. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, дүрэм, журмыг баримтлаагүй байна.
8. Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал хэвийн байна.



### **ГУРАВ. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доорх албан тушаалтнуудад зөвлөж байна.

#### *Боловсрол соёл урлагийн газрын дарга Б.Гантулгад:*

- Төсвийн шууд захирагч нарын албан хэрэг хөтлөлтийн чадварыг дээшлүүлэх, чадавхижуулахад анхаарч, дотоод хяналтыг сайжруулах
- Батлагдаагүй орон тоонд хавсран ажиллаж байгаа ажилтнуудыг хууль эрх зүйн актын дагуу гүйцэтгүүлэх талаар бодлогоор хангаж, хэрэгжүүлэх
- Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, хувийн цэцэрлэгүүдийн сургалтын нормативт зардлын санхүүжилтийг сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийг олгох

#### *Цэцэрлэгийн эрхлэгч нарт:*

- Хандив, тусламжийн орлогыг төрийн сангийн дансанд бүрэн төвлөрүүлэх
- Тушаал шийдвэргүйгээр нэмэгдэл хөлс олгохгүй байх
- Ажиллагсад ур чадварын нэмэгдлийг тэгш хүртээмжтэй олгох
- Цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулан олгохгүй байх
- Бараа материалын худалдан авалтыг хийхдээ зах зээлийн үнийг харгалзан үзэж, түүнээс өндрөөр бэлтгэхгүй байх
- Хоолны зардлыг батлагдсан нормативын дагуу зарцуулах
- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах
- Чанарын шаардлага хангахаа больсон, цаашид ашиглах боломжгүй, ашиглагдахгүй байгаа хөрөнгийг акталж устгах хүсэлт гарган, шийдвэрлүүлэх

Аудитаар илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт хийж, төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг гаргаж, 2019 оны 5 дугаар сарын 20-ны дотор Дархан-уул аймаг дахь Төрийн Аудитын газарт ирүүлэх

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
2018.11.20.

